

№	Оролцогчийн тодруулга	Хариулт
1	<p>Зөрчлийн хариуцлагын тухай дараах заалтыг хасаж өгнө үү. 8.1 Гэрээ зөрчсөний хариуцлага 8.1.4 дэх шинэ зүйл нэмэв: 6.3.1-д заасан Нөхөн төлбөрийн хязгаарыг үл харгалзан, хэрэв Төслийн ажлын аль нэг гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх хугацаагаа хойшлуулахаар холбогдох гэрээний дагуу амжилттайгаар нэхэмжилсэн бөгөөд ийнхүү хойшлуулсан нь Зөвлөх энэ Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зөрчсөнөөс шалтгаалсан гэж Захиалагч үзсэн бол тийнхүү хойшилсноос үүсэх хохирол, зардлыг Зөвлөхөөр нөхөн төлүүлэх эрхтэй.</p>	<p>Энэхүү нөхцөлийг хэлэлцээрийн шатанд шийдвэрлэнэ. ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.</p>
2	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.6.2.гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй; гэсэн байна. Энэ тендерт гэрээний шатанд хэлэлцэн тохиролцох зүйл, заалтууд олон байгааг харгалзан үзэж нь тус тендерт шалгарсан оролцогч гэрээний хэлэлцээний үед тохиролцоонд хүрч чадаагүй нөхцөлд тендерийн баталгаагаа хураалгах эрсдэл үүсэж байна. Иймд энэ эрсдэл байсаар байгаа цагт олон улсын зөвлөх компаниуд оролцох боломж олгохгүй байна. Энэ дээр шийдэл хэлж өгнө үү. Магадгүй нэг шийдэл нь оролцогчийг шалгаруулсан тохиолдолд түүний тендерт хамт ирүүлсэн гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг хүлээн зөвшөөрөх нөхцөлтэй байж болох юм.</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.6.2-т заасныг оролцогч дагаж мөрдөнө. ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ. Хэлэлцээрийн шатанд гаргасан саналыг тохиролцоно.</p>
3	<p>Гол экспертүүдын хүн-сарыг (man-month) тодорхой зааж өгөх ёстой.</p>	<p>Одоогийн гэрээний загвар нь ажлын үр дүн (Deliverables e.g), гэрээний үүргийн гүйцэтгэл (Milestone e.g)-тэй уялдуулж төлөхөөр томъёологдсон. ТЖББ-ийн “Гэрээ баталгаажуулах маягт”-ын Хавсралт 3-т “Гэрээний үнийн задаргаа, төлбөрийн нөхцөл ба журам” хүснэгтийг оролцогчдоос бөглөж ирүүлнэ. Энэхүү хүснэгтэд заасан мэдээллийг хэлэлцээрийн явцад талууд харилцан тохиролцож тодорхойлно.</p>

		Энэхүү хавсралтыг олон улсын тэргүүлэх туршлагад суурилан санал, шийдэл байдлаар ирүүлэх боломжтой.
5	FIDIC 2017 оны цагаан номын дагуу байсан арбитрын заалтыг сэргээх шаардлагатай.	Маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлэхээр заасан. ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ үү.
6	Гэрээний одоогийн нөхцөлөөр арилгагдсан хохирлыг тухайн жилийн гэрээний үнийн дүнгийн 2 хувиас ихгүй хэмжээгээр хязгаарлах хэрэгтэй.	Хохирлын тухай заалтыг гэрээний төсөлд тодорхой тусгасан. ТЖББ-ийн ТШЗ 38.2-т “Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.
7	Урьдчилгаа төлбөрийн заалт байх хэрэгтэй.	Төлбөрийн нөхцөлийг хэлэлцээрийн шатанд шийдвэрлэнэ. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлд зааснаар урьдчилгаа төлбөр олгох тохиолдолд тендерт оролцогч урьдчилгаа төлбөрөөс багагүй дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргахаар заасан. Урьдчилгаа төлбөр өгөхөөр тохиролцох нөхцөлд хүлээлгэн өгөх бичиг баримт (deliverables) болон ажлын үе шаттай (milestone) уялдуулж, эргэн төлөгдөх нөхцөлийг тодорхойлох (amortization) шаардлагатай.
8	Зөвлөхөд төлөх төлбөрийг одоогийн lump sum бус хүн сараар төлөх ёстой.	Одоогийн гэрээний загвар нь ажлын үр дүн (Deliverables e.g), гэрээний үүргийн гүйцэтгэл (Milestone e.g)-тэй уялдуулж төлөхөөр томъёологдсон. Үүнээс өөр санал байгаа бол саналаа тендерийн материалд ирүүлнэ үү.

9	<p>Тендерийн баримт бичгийн 6 дугаар бүлэг "Гэрээний хавсралт 4" Ажлын хөтөлбөр, ажлын хуваарь хүснэгтэд "Хийгдэж эхлэх болон хийгдэж дуусах ажил" хэсгийг үйлчилгээний ажил тус бүрийн сар бүрийн гүйцэтгэлийг бөглөнө гэж ойлгож байна.</p> <p>Гэвч РМС үйлчилгээний агуулга маш их ба ажил тус бүрээр хүснэгтийг бөглөвөл маш их, агуулгын хувьд төвөгтэй болох магадлалтай. Иймд хүснэгт доторх "Хийгдэж эхлэх болон хийгдэж дуусах ажил" хэсгийн бөглөх шаардлагатай юу? Хэрэв тийм бол хэрхэн бөглөх шаардлагыг захиалагчаас тодруулж байна.</p>	<p>Тендерт оролцогч энэхүү хавсралтад дурдсан мэдээллийг тендерийн баримт бичигт саналаар ирүүлэх бөгөөд гэрээний хэлэлцээрийн шатанд эцэслэн тохирно. Энэхүү хавсралтыг олон улсын тэргүүлэх туршлагад суурилан санал, шийдэл байдлаар ирүүлэх боломжтой. (Жишээ нь Gantt chart г.м.)</p>
10	<p>2.Тендерийн баримт бичгийн 5 дугаар бүлэг "Тендер шалгаруулалтын жишиг хэлбэр" маягт 5. Үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө, аргачлалын аргачлалыг "Гэрээний хавсралт 6"-д заасан хүснэгтийн "Ажлын аргачлал тайлбар" хэсэгт бөглөх шаардлагатай. Хэрэв бөглөх агуулга их тохиолдолд ажлын аргачлалын нарийвчилсан тайлбарыг хүснэгтийн арын хэсэгт дараалуулан бичиж, "Ажлын аргачлал тайлбар" баганад харгалзах тайлбарын дугаарыг бөглөх боломжтой юу?</p>	<p>Боломжтой. Олон улсын тэргүүлэх туршлагад суурилан санал, шийдэл байдлаар ирүүлэх болгох боломжтой.</p>